

Баян-Олгий аймгийн БТСГ-ын дарга Х.Хайнар Казахстан улсын дорнод Казахстан мужийн БТСГазарын дарга Елдос Чикиновтой уулзлаа.

Уулзалтын үеэр Оскемен хотод спортын 16 торлоор зохион байгуулагдаж байгаа бvх ард түмний спортын их наадмыг сонирхон, спортын барилга байгууламжуудтай танилцан туршлага судалжээ. Тус мужийн БТСГазар нь Баян-Олгий аймгийн тамирчдыг уралдаан тэмцээнд урьж оролцуулах, хамтарсан бэлтгэлд хамруулах, дасгалжуулагчдыг сургалт семинарт хамруулах зэрэг дэмжлэгүүдийг үзүүлж, хамтын ажиллагаагаа оргожүүлэхээр боллоо.

Дашрамд дурдахад 2016 оны 2 дугаар сард Казахстан улсын дорнод Казахстан мужийн БТСГазрын дарга Елдос Чикиновт Баян-Олгий аймгийн БТСГазрын дарга Х.Хайнар албан хүсэлт тавьсаны дагуу Баян-Олгий аймгийн таеквондо, бокс, хүндийн орголт гэх зэрэг спортын торлуудийн гурван дасгалжуулагч, есон тамирчны бүрэлдэхүүнтэй баг тамирчид долоо хоног туршлага судлан олон улсын тэмцээнд оролцсон билээ.